



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА

2019



Даланзадгад хот
2020 он

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	4
Зургийн жагсаалт	4
Үүсэл хөгжил, танилцуулга	5
Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын талаар	6
Дотоодын нийт бүтээгдэхүүн	12
Аж үйлдвэрийн салбар	14
Барилга	15
Тээвэр, Холбооны салбар	16
Дүгнэлт	19
Санал	20

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Статистикийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн У.Хоролмаа

Хаяг: Нутгийн Удирдлагын ордон 304 тоот

Утас: 70533439, 70533061

Цахим хаяг: umnugovi@nso.mn

Веб хаяг: www.umnugovi.nso.mn

www.1212.mn

Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс

Даланзадгад 2020 он

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

1. БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА бүс, аймаг, нийслэлээр 2015-2019 он
2. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА бүс, аймаг, нийслэлээр 2015-2019 он
3. БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ ХОРШОО, ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ГИШҮҮДИЙН ТОО, бүс, аймаг, нийслэлээр
4. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, бүс, аймаг, нийслэлээр, оны үнээр* 2016-2019 он
5. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, 2015-2019 он, оны үнээр, мян.төг
6. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, 2015-2019 он биет хэмжээгээр
7. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ сая.төг
8. ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ
9. АВТО ТЕХНИКИЙН УЛСЫН ҮЗЛЭГ
10. ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

1. НИЙТ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО 2015-2019
2. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН 2015-2019 ОНООР /сая төг/
3. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНД /салбаруудын эзлэх хувь/
4. НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН / сая.төг/
5. АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, 2015-2019 оноор, оны үнээр, сая.төг
6. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ сая.төг
7. АВТО МАШИНЫ УЛСЫН ҮЗЛЭГИЙН ДҮН 2017-2019 он /бүтцээр/
8. ХОЛБООНЫ САЛБАРЫН НИЙТ ОРЛОГО 2016-2019 он сая.төг
9. ТЕЛЕФОН ЦЭГИЙН ТОО 2015-2019 он

АЙМГИЙН АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ТАНИЛЦУУЛГА

Манай аймаг анх 1931 оны өнт хонин жилийн хавар 2-р сард Өмнөговь аймаг байгуулагдаж, хацрын ар усанд түр байрлаж байсан худалдааны жижиг салбарыг нүүлгэн далангийн голын ард буулгаж аймгийн хоршоо болгон ашиглаж Лхагва, Дандар нарын 2 орон тоотойгоор ажиллуулсан нь худалдаа эрхлэгчдийн хоршооны тус аймаг дахь үндэс суурь нь болсон ба энэ хоршоо нь тухайн үеийн ханшаар 20 гаруй мянган төгрөгийн бараатай 2 эсгий гэртэй байв.

Энэ үеээс хойш аймгийн нийт сумдад хоршоо худалдааны салбарууд байгуулагдаж хөдөө нутгийн олон ардуудыг анхны хоршооны гишүүнээр элсүүлж, тусгай хэвлэмэл үнэмлэх олгож, тэдэнд зарим төрлийн хөнгөлөлт эдлүүлэх зэрэг ажил зохиогдож байв. Үүний зэрэгцээ ХАА-н үйлдвэрлэлд аян жин тээх, малын хашаа барих, худаг ус гаргах, ан агнах, хадлан тэжээл бэлдэх зэрэг ажилд хүч хөдөлмөрөө хамтран ажиллах зайлшгүй шаардлага гарч байв. Энэ шаардлагын дагуу Мандал-Овоо, Баяндалай, Ноён сумын зарим ардын аж ахуйтан хөдөлмөрөө хорших санаачлага гаргаж. 1937 онд Мандал-Овоо сумын ард Чосров, Даваа нар санаачлан 17 хүн сайн дураараа санал нэгдэн “Ангийн нөхөрлөл байгуулж, хамтын хүчээр ан агнаж мах, арьсыг нь худалдаанд тушааж орлогоо хувааж авдаг болсон байна. Мөн 1939 оны намар Ноён сумын малчин ард М.Даваа тэргүүтэй 5 малчин хамтран Дов сүүжийн булгийн түшиглэн жингийн нөхөрлөл байгуулж байсан нь одоогийн Гурван тэс сумын “Соёл” Нэгдлийн суурь нь байсан юм. Мөн 1930 аад оны дундуур байгуулагдсан үйлдвэрлэлийн хоршоодын артелиуд өргөжин тэлсээр байсан бөгөөд аймгийн төвийн артель 1950 иад оны дунд үеэс гар үйлдвэрлэлийн хоршооллын артель болон өргөжиж байв.

Улмаар 1990 оноос хойш зах зээлийн нийгэмд шилжин орчин цагийн буюу шинэ үеийн үйлдвэрлэл үйлчилгээ, худалдаа барилгын салбарын үндэс тавигдсан байна.

“Таван толгойн уурхай”-н түүхэн замнал

Хуучин Түшээт хан аймгийн Говь-Түшээ” гүний хошууны “Их Шанхай” уулын ойролцоо одоогийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын “Сийрт” багийн нутаг “Өгөөмөр” уулын баруун хойд үзүүрт “Цэций” уулын ард таван жижиг толгодын нэрээр нэрлэгдэн тогтсон Тавантолгой нүүрсний орд нь 8 аймгийнхаа төвөөс 96 км, сумаасаа 14 км, Улаанбаатар хотоос 550 км, Дорноговь аймгийн төмөр замын Сайншанд өртөөнөөс 470 километрийн зайд оршдог. Тавантолгойн нүүрсний орд нь, эрт дээр үеэс энгийн байдлаар хөрсөнд ил гарч, ардын хувьсгалын жилүүдэд ЗХУ, болон социалист бусад улс орны ба өөрийн орны геологичдын хамтарсан шинжилгээ судалгаагаар нээгдсэн дэлхийд алдартай коксжих нүүрсний том орд газар юм. 1934-1935 оноос, энд чулуун нүүрс байдаг гэдгийг ажил хичээнгүй ажигч гярхай нутгийн ардууд, ахмад буурлууд, уран дархчуул тухайн үедээ мэдэж, амьдрал ахуйдаа тэмээнд нуруу ачаалан хэрэглэж, үр дүнгий нь үзсэнээс улбаалан 1936 оноос сум, аймгийн хамгаалалтанд авч, гар аргаар түлшинд хэрэглэж эхэлсэн байна. 1939 оны сүүлч 1940- оноос эхлэн Цогтцэций сум дахь үйлдвэр-хоршооллын артельд Тавантолгойн чулуун нүүрсийг шилжүүлэн, гар аргаар гарган авч аймгийн төвд борлуулж эхэлснээр анхныхаа ажил үйлчилгээний гараанд гарч улмаар БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1966 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор тус орд газрыг улсын болгож, үйлдвэрийн аргаар ашиглахаар шийдвэрлэн Аж Үйлдвэрийн Яаманд шилжүүлэн өгч, Дундговь аймгийн Цагаан-Овоогийн нүүрсний уурхайн цэг болгон ажиллагчид 8, үүнээс ажилчид гуравтайгаар зохион байгуулагдаж, анх удаа 3000 тн нүүрс гаргаж борлуулах улсын төлөвлөгөөг

хүлээн авч ажиллажээ. Улмаар аж үйлдвэрийн яамны 1967 оны 4-р сарын 25-ны өдрийн 64 тоот тушаалаар Сайд нарын Зөвлөлийн 30-р тогтоолыг үндэслэн 1967 оны 5-р сарын 1-ний өдрөөс биеэ даасан уурхайн захиргаа болгон байгуулсан байна. Энэ үед нийт 15 ажиллагсадтай, үүнээс ажилчид 6, инженер 3-302-нэг, ЖЭС-60, дизель станц-нэг, үйлчилгээний ГАЗ-53 машин-нэг, ус зөөврийн ЗИЛ-164 цистерн-нэг, конторын эсгий гэр-нэг, ажилчдын сууцны эсгий гэр-тав бүгд -230.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэйгээр ирж байрласан бөгөөд анхны даргаар Цагаан-Овоогийн нүүрсний уурхайд мастераар ажиллаж байсан, Ханбогд сумын харъяат Сэрээтэрийн Хүүхэнжав томилогдон ажиллажээ. Ийнхүү анхныхаа жилд 4300 тонн нүүрс гаргаж борлуулах, 1500 м³ хөрс хуулах улсын төлөвлөгөөт даалгавар хүлээн авч 107.2-133.3 хувиар биелүүлсэн бахдам сайхан амжилтаар гараагаа эхэлсэн байна. 1978-1980 онуудад уулын үндсэн тоног төхөөрөмжүүд шинэчлэгдэн Э-10011 энкскаватор, краз-256 автосамосвал, СБВ-2 м өрмийн машин, ЭСД-100 дизель станцуудаар хангагдаж байсан бол 1980-1990-ээд онд ЭО-5111 экскаваторууд, автогрейдер. Т-170, Т-130 бульдозерууд зэргээр уулын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг шинэчлэн, автопарк үйлчилгээний машин техникүүдээр шинэчлэгдэн жилдээ 120000 тн нүүрс олборлон борлуулах хүчин чадалтай орон нутгийн чанартай томоохон уурхай болон өргөжсөн байна.

Монгол Улсын Засгийн Газраас орон нутгийн уурхайнуудыг өргөтгөх хүчин чадлыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд болон Даланзадгадын Дулааны Цахилгаан станц ашиглалтанд орсноор уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлдвэрийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор 2000 оноос коматцу Д-65 бульдозер. РС-220 экскаватор, 25 тн-ийн даацтай терекс автосамосвал 2 ш зэргээр парк шинэчлэлтийг дахин хийснээр өнөөдөр үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Манай уурхайн хамт олон, түүхийн 40-н жилийн хугацаанд Өмнөговь аймгийн нийт сум, төвийн хэрэглэгчид, Дорноговь аймгийн хилийн залгаа сумдууд, цэргийн анги, Дундговь аймгийн төв болон ойрын сумдын нүүрсний хэрэгцээг хангаж ирсний зэрэгцээ 1990-1991 онд Хөтлийн цемент шохойн үйлдвэр, Улаанбаатар хотын 3-р цахилгаан станцад нүүрс нийлүүлж байснаас гадна 2004 оноос БНХАУ-д нүүрс экспортлох гэрээ хийснээр 2006 он гэхэд хугацаанд нүүрс борлуулалтын хэмжээ эрс нэмэгдэж нийт 2.8 сая тн нүүрс олборлож, 2.9 сая тн хөрс хуулсан амжилттай байна. 2001 оноос эхлэн манай аймагт олон томоохон уурхайнууд шинээр бий болж аймгийн тэргүүлэх салбар болон хөгжсөөр байна.


Монгол Улсын нүүрс олборлолт, экспорт, дотоодын хэрэгцээ сүүлийн таван жилд гурав дахин өсч, үүний 90 орчим хувийг Өмнөговь аймгийн нутагт үйл ажиллагаагаа явуулдаг компаниуд бүрдүүлж байна. Үүнээс орон нутгийн өмчит “Тавантолгой” ХК-ийн орон нутгийн төсөвт оруулж буй хувь нэмэр хамгийн их юм.

Өмнөговь аймагт 80 гаруй орд, 200 гаруй илрэл тогтоогдож, ашиглалтын 98, хайгуулын 155 лиценз хүчин төгөлдөр байгаагаас ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа 12 аж ахуйн нэгж байна.

Эдгээрээс Таван толгой, Нарийнсухайт, Оюу толгой зэрэг орд газрууд нь Монгол Улсын стратегийн ач холбогдолтой ордод хамаарагддаг бөгөөд сүүлийн жилүүдэд Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд томоохон түлхэц болж байна.

Мөн Ашигт малтмалын тухай хуулийн дагуу “Оюу толгой” ХХК, “Эрдэнэс таван толгой” ХК, “Энержи ресурс” ХХК, “Терра энержи” ХХК-иудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна.

БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТАЛААР



Монгол улсад нийт бүртгэлтэй 187046 аж ахуйн нэгж, байгууллага байгаагийн 1.6 хувь, төвийн бүсийн 17.8 хувийг Өмнөговь аймгийн аж ахуйн нэгж, байгууллага эзэлж байна. / ХҮСНЭГТ 1/

ХҮСНЭГТ 1. БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА бүс, аймаг, нийслэлээр 2015-2019 он

Аймаг, нийслэл	2015	2016	2017	2018	2019
Улсын дүн	126560	141502	155065	174936	187046
Төвийн бүс	11700	12587	13804	15516	16304
Говьсүмбэр	351	398	439	469	492
Дархан-Уул	3196	3480	3768	4000	4154
Дорноговь	1181	1298	1439	1640	1751
Дундговь	861	907	965	1071	1118
Өмнөговь	1797	1966	2256	2731	2906
Сэлэнгэ	2528	2619	2894	3411	3543
Төв	1786	1919	2043	2194	2340


2019 онд бизнес регистрийн санд бүртгэлтэй 2906 аж ахуйн нэгж, байгууллагаас үйл ажиллагаа явуулж байгаа нь 1754 байна. Бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын тоо 2015 оноос 645 буюу 58.1 хувь, өнгөрсөн оноос 81 буюу 4.8 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 2. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА бүс, аймаг, нийслэлээр 2015-2019 он

Аймаг, нийслэл	2015	2016	2017	2018	2019
Улсын дүн	64301	72182	78585	87725	93820
Төвийн бүс	7862	8499	9050	9724	10108
Говьсүмбэр	278	313	302	374	384
Дархан-Уул	1811	1973	2130	2198	2254
Дорноговь	922	1002	1069	1192	1261
Дундговь	585	601	639	671	705
Өмнөговь	1109	1281	1429	1673	1754
Сэлэнгэ	2032	2108	2214	2300	2372
Төв	1125	1221	1267	1316	1378

Дээрх бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын тоо өссөнтэй уялдаатайгаар мөн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын тоо жил ирэх тусам өсөлттэй байна. /ХҮСНЭГТ 1/, /ХҮСНЭГТ 2/, /ЗУРАГ 1/

ЗУРАГ 1. НИЙТ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО 2015-2019 он



ХҮСНЭГТ 3. БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА сумдаар, 2015-2019 он


Үзүүлэлт	2015-IV	2016-IV	2017-IV	2018-IV	2019-IV
Баяндалай	36	35	35	41	44
Баян-Овоо	34	39	43	51	54
Булган	40	40	43	50	57
Гурвантэс	79	82	98	115	129
Мандал-Овоо	30	31	36	49	49
Манлай	38	40	48	54	55
Номгон	36	39	45	47	49
Ноён	31	33	39	39	42
Сэврэй	28	29	30	38	41
Ханбогд	246	280	329	411	471
Ханхонгор	36	37	39	39	42
Хүрмэн	24	25	26	26	27
Цогт-Овоо	33	38	44	49	51
Цогтцэций	210	231	251	287	314
Даланзадгад	896	987	1,150	1,348	1,481
Нийт дүн	1,797	1,966	2,256	2,644	2,906

Өмнөговь аймгийн хэмжээнд 2019 оны 4 дүгээр улирлын байдлаар 1754 аж ахуй, нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүний 49.9 хувийг Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллага эзэлж байна. Харин үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуй нэгж байгууллагын 1.2 хувийг Хүрмэн суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүд эзэлж байна./ ЗУРАГ-2 /

ХҮСНЭГТ 4. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА сумдаар, 2015-2019 оны IV улиралаар

Үзүүлэлт	2015-IV	2016-IV	2017-IV	2018-IV	2019-IV
Өмнөговь	1,109	1,281	1,429	1,629	1,754
Баяндалай	27	26	26	29	29
Баян-Овоо	27	32	36	41	44
Булган	35	35	37	37	40
Гурвантэс	55	58	64	75	83
Мандал-Овоо	22	22	25	38	36
Манлай	30	31	32	39	41
Номгон	25	28	30	29	31
Ноён	24	25	27	25	26
Сэврэй	21	23	24	29	31
Ханбогд	142	175	195	230	259
Ханхонгор	26	28	29	26	30
Хүрмэн	19	20	21	21	21
Цогт-Овоо	21	24	29	32	32
Цогтцэций	108	125	132	153	176
Даланзадгад	527	629	722	825	875

ХҮСНЭГТ 2. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, сумдаар 2019 оны эцсээр



2018 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын хэмжээнд бизнес регистрийн санд бүртгэлтэй 4477 хоршоо, төвийн бүсэд 776, Өмнөговь аймагт 97 хоршоо байна. Энэ нь өмнөх оныхоос 7 хоршоогоор нэмэгдсэн бөгөөд 5051 гишүүдтэй байна.

БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ ХОРШОО, ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ГИШҮҮДИЙН ТОО, бүс, аймгаар

ХҮСНЭГТ-3

Аймаг, нийслэл	Хоршоо		Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, сая төг		Гишүүдийн тоо	
	2017	2018	2017	2018	2017	2018
Улсын дүн	4377	4477	45699.9	48234.6	209314	223421
Төвийн бүс	756	776	6674.1	6980.1	32555	33668
Говьсүмбэр	22	26	161.6	170.9	834	924
Дархан-Уул	125	121	387.7	397.4	2253	2317
Дорноговь	67	67	770.3	768.7	3703	3762
Дундговь	101	102	2414.1	2418.4	7936	7841
Өмнөговь	90	97	325.1	343.2	4388	5051
Сэлэнгэ	169	175	1036.3	1078.5	4366	4466
Төв	182	188	1579.0	1803.0	9075	9307

БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ ХОРШОО, ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ГИШҮҮДИЙН ТОО, сумдаар, 2018 оны эцэст

	Хоршоо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, сая төг	Гишүүдийн тоо
Баяндалай	5	32.5	354
Баян-Овоо	4	18.3	213
Булган	7	22.3	255
Гурвантэс	7	5.4	405
Мандал-Овоо	5	11.5	185
Манлай	6	21.0	249
Номгон	9	54.6	436
Ноён	3	29.0	197
Сэврэй	5	5.1	265
Ханбогд	14	19.3	465
Ханхонгор	6	9.6	129
Хүрмэн	3	2.6	59
Цогт-Овоо	3	62.0	374
Цогтцэций	3	6.2	29
Даланзадгад	17	43.8	1,436
Нийт дүн	97	343.2	5,051

2018 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд бизнес регистрийн санд бүртгэлтэй 97 хоршоонд хувь нийлүүлсэн хөрөнгө 343.2 сая төгрөг байна.

1. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН



Урьдчилсан гүйцэтгэлээр 2019 онд Өмнөговь аймаг Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 2.3 хувь, төвийн бүсийн 20.5 хувь болох 728.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагийн дээр нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 10.5 сая төгрөг болж улсын хэмжээнд Орхон аймаг, Улаанбаатар хот, Дорнод аймгийн дараа 4-т, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт дүнгээр 3655.9 тэрбумд хүрсэн байна.

ХҮСНЭГТ 4. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, бүс, аймаг, нийслэлээр, оны үнээр* 2016-2019 он


	2016			2017**				
	ДНБ, сая төг	Дүнд эзлэх хувь			ДНБ, сая төг	Дүнд эзлэх хувь		
		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ
Дүн	23 942 866.4	11.5	36.6	51.8	27 876 297.2	10.1	41.4	48.5
Төвийн бүс	2 439 043.8	29.7	35.2	35.2	2 870 828.4	25.0	41.9	33.2
Говьсүмбэр	83 354.9	20.0	38.3	41.7	83 959.4	20.8	38.0	41.2
Дархан-Уул	387 260.4	9.7	42.1	48.2	409 544.4	8.2	46.3	45.6
Дорноговь	272 288.4	25.6	18.1	56.4	296 014.8	27.3	17.4	55.3
Дундговь	226 072.5	55.1	14.1	30.7	258 177.0	56.7	14.7	28.6
Өмнөговь	404 035.8	22.5	42.9	34.7	714 470.2	14.7	57.5	27.8
Сэлэнгэ	555 423.0	23.9	48.1	28.0	598 216.1	20.9	51.2	27.9
Төв	510 608.8	49.4	27.6	23.0	510 446.5	40.9	34.0	25.0
	2018			2019**				
	ДНБ, сая төг	Дүнд эзлэх хувь			ДНБ, сая төг	Дүнд эзлэх хувь		
		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ
Дүн	32 411 224.1	10.1	41.4	48.5	32 093 615.4	10.7	42.2	47.1
Төвийн бүс	3 155 898.1	31.7	34.9	33.4	3 552 301.1	31.7	34.9	33.4
Говьсүмбэр	89 146.0	20.8	38.0	41.2	97 640.2	22.6	34.2	43.2
Дархан-Уул	428 447.5	8.2	46.3	45.6	474 710.7	9.2	44.1	46.7
Дорноговь	368 335.5	27.3	17.4	55.3	405 359.7	31.3	20.6	48.1
Дундговь	328 291.5	56.7	14.7	28.7	380 983.3	60.2	16.4	23.4
Өмнөговь	657 803.3	14.7	57.5	27.8	728 463.3	19.8	48.1	32.1
Сэлэнгэ	689 576.9	20.9	51.2	27.9	776 341.0	25.7	48.0	26.4
Төв	594 297.4	40.9	34.0	25.0	688 802.9	47.6	29.9	22.5

* Нөөц, ашиглалтын хүснэгтийн 2016 -2019 оны үр дүнгээр тодотгов.

** Урьдчилсан гүйцэтгэл

Өмнөговь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2015-2019 тогтвортой өсөлттэй байгаа нь дараах графикаас тодорхой харагдаж байна. /ЗУРАГ 2/

ЗУРАГ 2. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН 2014-2018 ОНООР /сая төг/




Дотоодын нийт бүтээгдэхүүнийг салбараар нь авч үзвэл:

Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар 19.8 хувь,

Аж үйлдвэр, барилгын салбар нь 48.1 хувь,

Үйлчилгээний салбар 32.1 хувийг тус тус эзэлж байна. /Хүснэгт 4/, /Зураг 3/

ЗУРАГ 3. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН /салбаруудын эзлэх хувь/




Дээрх зургаас харахад хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь өмнөх оныхоос өссөн байхад, аж үйлдвэр, барилгын салбарын эзлэх хувь 9.4 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.


Өмнөговь аймгийн нэг хүнд ногдох Дотоодын нийт бүтээгдэхүүн нь 2015 онд 4.6 сая, 2016 онд 6.4 сая, 2017 онд 11.0 сая, 2018 онд 9.7 сая, 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 10.5 сая төгрөгт хүрсэн байна.

Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн нь 2015-2017 онуудад өсөлттэй, харин 2018 онд 1.3 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байсан ч 2019 онд эргээд өсөлт (0.8 пункт) харагдаж байна./Зураг 4/

Зураг 4. НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН / сая.төг/



3. АЖ ҮЙЛДВЭР




2019 онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 3655.9 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 54.8 хувиар буюу 1294.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний эзлэх хувиар нь авч үзвэл: уул, уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулалт 99.5 хувийг эзэлж байна. /Хүснэгт-5/ /ЗУРАГ-6/

ХҮСНЭГТ 5. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, 2015-2019 оноор

Бүтээгдэхүүний нэрс	Хэмжих нэгж	Биет хэмжээ					2019 2018
		2015	2016	2017	2018	2019	
Чулуун нүүрс	мян.тн	9771.2	17691.2	22884.8	20844.3	27374.80	131.3
Алт	кг		3.1			0.9	
Дулааны эрчим хүч	мян.Гкал	43.5	50.1	50.6	59.0	58.1	98.5
Боловсруулсан шингэн сүү	мян.л	47.3	28.8	43.8	48.0		
Архи	мян.л	12.9	12	9.6	12.5	14.9	119.2
Хийжүүлсэн ус	мян.л					3121	
Түгээсэн цэвэр ус	мян.м3	228.1	253.1	272.6	245.4	311.8	127.1
Сувагжуулалт	мян.м3	169.3	195.6	213.9	203.9	238.1	116.8

ЗУРАГ 6. ЧУЛУУН НҮҮРС ОЛБОРЛОЛТ, 2015-2019 он, мян.тн




Өмнөговь аймгийн хэмжээнд аж үйлдвэрийн салбарын борлуулалт сүүлийн 5 жилд тогтмол өсөлттэй байна. /ЗУРАГ 5 /

2019 оны эцэст 3605.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 899.4 тэрбум төгрөгөөр буюу 33.2 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн борлуулалтыг салбараар авч үзвэл уул уурхай, олборлох аж үйлдвэр 3586.2 тэрбум төгрөг, хүнсний боловсруулах аж үйлдвэр 15.1 тэрбум төгрөг, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн борлуулалт 4.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.

ЗУРАГ 7. АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, 2015-2019 оноор, оны үнээр, сая.төг



4. БАРИЛГА




Барилга угсралт их засвар гэж барилга байшин барих болон инженерийн зориулалтаар зам гүүр, далан угсрах зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэгдсэн үйл ажиллагааг ойлгоно.

ХҮСНЭГТ 6. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ сая.төг

	2016	2017	2018	2019
Улсын дүн	2928735.2	2926822.1	4009817.5	4747504.2
Төвийн бүс	443219.8	821381.4	1417255.0	1738541.2
Говьсүмбэр	10689.8	3802.1	3423.1	14551.8
Дархан-уул	79659.2	38812.8	91114.5	109825.6
Дорноговь	17046.2	95213	423281.8	170117.4
Дундговь	11230.2	8003.1	9515.0	146164.5
Өмнөговь	295485.2	562661.7	732711.8	1135373.4
Сэлэнгэ	9146.0	83716.1	13216.6	41790.3
Төв	19963.1	29172.6	143992.2	120718.2

Барилга угсралт, их засварын ажилд Өмнөговь аймаг 2019 онд 1135.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл хийсэн нь 2018 оноос 54.0 хувиар өсч, төвийн бүсийн дүнд 65.3 хувь, улсын дүнд 23.9 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 9. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ сая.төг



5.ТЭЭВЭР, ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО, РАДИО ЦЭГИЙН ТОО ТЭЭВЭР ҮЙЛЧИЛГЭЭ



Тээврийн салбарын статистик үндсэн үзүүлэлтүүдэд ачаа эргэлт, тээсэн ачаа, зорчигч эргэлт, авто машины тоо, шилжүүлсэн тонн.км, ажиллагсдын тоо орлого зэрэг орно.

Авто тээврийн статистик мэдээ тайланг аж ахуйн нэгжүүдээс аймгийн статистикийн хэлтэс цуглуулан авч нэгтгэн Үндэсний

статистикийн хороонд дамжуулдаг.

Тээсэн ачаа эргэлт: Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг зөөвөрлөсөн зайгаар үржүүлсэн үзүүлэлт

Зорчигч тээвэр эргэлт: Нийт зорчигчдын тоог тээвэрлэсэн зайгаар үржүүлсэн хэмжээ 23.8.5 мян.тн ачаа тээвэрлэж, 6183.8 мян.тн.км-ийн ачаа эргэлт хийсэн нь өнгөрсөн оноос тээсэн ачаа 9.3 мян.тн-оор өсч, ачаа эргэлт 42.0 хувиар өссөн гүйцэтгэлтэй байна.

Тээвэр бүхий байгууллагууд 3202 мянган хүн тээвэрлэж, 188054.3 мян.хүн.км-ийн зорчигч эргэлт хийсэн нь өнгөрсөн оноос Зорчигч тээвэрлэлт 11.9 хувиар буюу 342,3 мян.хүнээр өсч, зорчигч эргэлт 2 дахин буюу 98017.9 мян.хүн.км-ээр өссөн гүйцэтгэлтэй байна.

Тээврийн орлого 13053.5 сая төгрөг болж өнгөрсөн оноос 51.8 хувиар буюу 4458.4 сая төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 7. ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017	2018	2019	2019/2018
Ачаа эргэлт	мян.тн.км	65206.6	4355.3	6183.8	142.0
Тээсэн ачаа	мян.тн	437.5	14.5	23.8	164.0
Зорчигч эргэлт	мян.хүн.км	172262	90036.4	188054	200.0
Үүнээс: дотоодод	мян.хүн.км	172262	90036.4	188054	200.0
Тээсэн зорчигч	мян.хүн	1314.8	2859.7	3202	111.9
Үүнээс: дотоодод	мян.хүн	1314.8	2859.7	3202	111.9
Тээврийн орлого	сая.төг	12725.8	8595.1	13053.5	151.8
Тээврийн ажиллагсад	хүн	466	386	428	110.8

ХҮСНЭГТ 8. АВТО ТЕХНИКИЙН УЛСЫН ҮЗЛЭГ


Аймаг нийслэл	2017	2018	2019	Үүнээс:						
				Төрлөөр				Ашигласан хугацаагаар		
				суудлын	ачааны	автобус	тусгай зориулалтын	3 жил хүртэл	4-9 жил	10-аас дээш
Бүгд	536 399	585363	614753	426065	131573	18570	9155	13408	126462	474883
Төвийн бүс	60 425	67905	89458	54254	32038	1166	2000	1617	14401	73440
Говьсүмбэр	2 333	2311	2338	1639	607	38	54	29	402	1907
Дархан-Уул	9 152	8941	15784	12190	3270	176	148	107	2525	13152
Дорноговь	11 155	11909	12567	8535	3590	183	259	183	2110	10274
Дундговь	2 954	2818	7821	4566	3043	125	87	78	997	6746
Өмнөговь	16 487	22700	22328	10865	9860	352	1251	1014	5523	15791
Сэлэнгэ	10 403	11219	16044	9921	5857	156	110	91	1794	14159
Төв	7 941	8007	12576	6538	5811	136	91	115	1050	11411

Эх үүсвэр: Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын мэдээлэл

Улсын хэмжээний нийт 614.7 мянган авто машины 3.6 хувийг манай аймагт бүртгэлтэй тээврийн хэрэгсэл эзэлж байна. Манай аймгийн хэмжээнд 2019 онд авто техникийн улсын үзлэгээр бүх төрлийн авто машин 22328 болж өнгөрсөн оноос 1.7 хувиар буюу 372 тээврийн хэрэгслээр буурсан байна.

ЗУРАГ 10. АВТО МАШИНЫ УЛСЫН ҮЗЛЭГИЙН ДҮН 2019 он /бүтцээр/

Авто машиныг төрлөөр нь авч үзвэл: 42 хувь буюу 10.8 мянга нь суудлын авто машин, 39 хувь буюу 9.8 мянга нь ачааны, 14 хувь буюу 3526 автобус 5 хувь буюу 1.2 тусгай зориулалтын авто машин байна.



ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО, РАДИО ЦЭГИЙН ТОО

Холбооны нийт орлого,үүнээс хүн амаас орсон орлого телефон болон радио цэгийн тоо зэрэг үндсэн үзүүлэлтийг харуулав.

Нийт орлого Холбооны үйл ажиллагааны нийт орлого гэдэгт цахилгаан холбоо, хөдөлгөөнт холбоо, мэдээллийн технологи, шуудангийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж,байгууллагуудын тайлант хугацааны нийт орлогыг оруулна.


Үүрэн телефон хэрэглэгч Тухайн байгуулсан сүлжээний хүрээнд хөдөлгөөнтэй /нэгээс нөгөө үүрт шилжих/ашиглах боломжтой утасгүй холбооны хэрэглэгч юм.

ХҮСНЭГТ 9. ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2019/2018
Нийт орлого	сая.төг	411.2	422.4	403.3	631	156.4
Хүн амаас олох орлого	сая.төг	165.8	64.5	47.3	94.7	200
Телефон цэг	ш	1188	950	912	902	98.9

2019 онд холбооны нийт орлого 631 сая.төг болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 56.4 хувиар буюу 227.7 сая төгрөгөөр өссөн байна. Хүн амаас олох орлого нь 94.7 сая.төг болж өнгөрсөн оноос 1 дахин буюу 47.4 сая.төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 15.0 хувийг хүн амаас орох орлого эзэлж байна.

ЗУРАГ 11. ХОЛБООНЫ САЛБАРЫН НИЙТ ОРЛОГО, оноор, сая.төг



Дүгнэлт, санал

2019 онд бизнес регистрийн санд бүртгэлтэй 2906 аж ахуйн нэгж, байгууллагаас үйл ажиллагаа явуулж байгаа нь 1754 байна. Бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын тоо 2015 оноос 645 буюу 58.1 хувь, өнгөрсөн оноос 81 буюу 4.8 хувиар тус тус өссөн байна. Дээрх бүртгэлтэй аж ахуй нэгж байгууллагын тоо өссөнтэй уялдаатайгаар мөн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын тоо жил ирэх тусам өсөлттэй байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд 2019 оны 4 дүгээр улирлын байдлаар 1754 аж ахуй, нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүний 49.9 хувийг Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллага эзэлж байна. Харин үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуй нэгж байгууллагын 1.2 хувийг Хүрмэн суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүд эзэлж байна.

Урьдчилсан гүйцэтгэлээр 2019 онд Өмнөговь аймаг Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 2.3 хувь, төвийн бүсийн 20.5 хувь болох 728.5 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагийн дээр нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 10.5 сая төгрөг болж улсын хэмжээнд Орхон аймаг, Улаанбаатар хот, Дорнод аймгийн дараа 4-т, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт дүнгээр 3655.9 тэрбумд хүрсэн байна.

Өмнөговь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2015-2017 онуудад тогтмол өсөлттэй байсан боловч 2018 онд буурсан байна. 2019 онд өсөлт харагдаж өмнөх оныхоос 10.8 хувиар, 2017 оныхоос 1.9 хувиар тус тус өссөн урьдчилсан үзүүлэлттэй байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүнийг салбараар нь авч үзвэл:

Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар 19.8 хувь,

Аж үйлдвэр, барилгын салбар нь 48.1 хувь,

Үйлчилгээний салбар 32.1 хувийг тус тус эзэлж байна.

Хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь өмнөх оныхоос өссөн байхад, аж үйлдвэр, барилгын салбарын эзлэх хувь 9.4 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Өмнөговь аймгийн нэг хүнд ногдох Дотоодын нийт бүтээгдэхүүн нь 2015 онд 4.6 сая, 2016 онд 6.4 сая, 2017 онд 11.0 сая, 2018 онд 9.7 сая, 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 10.5 сая төгрөгт хүрсэн байна.

Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн нь 2015-2017 онуудад өсөлттэй, харин 2018 онд 1.3 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байсан ч 2019 онд эргээд өсөлт (0.8 пункт) харагдаж байна.

Өмнөговь аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан “Бүтээн байгуулалт”- ажлын хүрээнд Орон нутгийн дэд бүтцийн хөгжлийг сайжруулах, автозамын сүлжээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлж, сүүлийн 5 жилд орон нутгийн төсвөөс томоохон хөрөнгө оруулалт хийгджээ.

Барилга угсралт, их засварын ажилд Өмнөговь аймаг 2019 онд 1135.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл хийсэн нь 2018 оноос 54.0 хувиар өсч, төвийн бүсийн дүнд 65.3 хувь, улсын дүнд 23.9 хувийг эзэлж байна.

2011 оноос манай аймагт тээвэр авто замын газар байгуулагдсан нь тээврийн салбарын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах таатай орчинг

бүрдүүлсэн. Тус аймгийн тээврийн салбарын дийлэнх хэсэг нь хувьчлагдаж, хувийн тээврийн үйлчилгээ зонхилж байгаа ч шуудан тээврийн үйлчилгээ сэргэж, авто вокзал шинээр баригдаж шинээр нэгдсэн зохион байгуулалтад орж байна.

Одоо Улаанбаатар Даланзадгадын чиглэлд өдөр бүр, аймгийн зүүн талын сумдад 7 хоногт 2 удаа зорчигч тээврийн үйлчилгээг нийслэлээс шууд үзүүлдэг, хөдөөгийн сумдад аймгийн төвөөс 7 хоног бүрт 2 удаа шуудан хүрч үйлчилж байна. Иймд тээврийн салбарын үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд жилээс жилд өссөн үзүүлэлтэй байна.

Тээвэр бүхий байгууллагууд 3202 мянган хүн тээвэрлэж, 188054.3 мян.хүн.км-ийн зорчигч эргэлт хийсэн нь өнгөрсөн оноос Зорчигч тээвэрлэлт 11.9 хувиар буюу 342,3 мян.хүнээр өсч, зорчигч эргэлт 2 дахин буюу 98017.9 мян.хүн.км-ээр өссөн гүйцэтгэлтэй байна.

Тээврийн орлого 13053.5 сая төгрөг болж өнгөрсөн оноос 51.8 хувиар буюу 4458.4 сая төгрөгөөр өссөн байна.

Сүүлийн жилүүдэд холбоо харилцааны систем эрчимтэй хөгжиж бүх сум шилэн кабелийн сүлжээ, үүрэн холбооны 3-5 операторт холбогдсноор хүссэн цагтаа хэрэгцээт мэдээллээ олж авах, дэлхий аль ч өнцөгт холбоо тогтоох боломж бүрдээд байна.

2019 онд холбооны нийт орлого 631 сая.төг болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 56.4 хувиар буюу 227.7 сая төгрөгөөр өссөн байна. Хүн амаас олох орлого нь 94.7 сая.төг болж өнгөрсөн оноос 1 дахин буюу 47.4 сая.төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 15.0 хувийг хүн амаас орох орлого эзэлж байна.

ЦААШИД ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭРХ САНАЛ:

- Шинээр байгуулагдаж байгаа Аж ахуйн нэгж байгууллагууд онцгой зөвшөөрөл авахын тулд 1-2 хүний бүрэлдхүүнтэй ХХК болж үүсч байгаа нь санхүүгийн талаар ямар ч мэдэгдэхүүнгүй нэг гэр бүлийн хоёр хүн дарга, нягтлан бодогч гэж бүртгүүлснээс статистикийн мэдээ тайлан гаргах, анхан шатны баримт хөтлөх талаар ямар ч ойлгоцгүй байна. Иймд ААН Байгууллага шинээр бий болоход тодорхой босго тавьж өгөх шаардлага гарч байна.
- Манай албан ёсны статистикийн 21-нд дамжуулдаг мэдээ болон холбооны мэдээний хугацаа нь сангийн яамны мэдээний хугацаанаас зөрж байдаг учир аж ахуйн нэгжүүдийн мэдээ тайлан зөрөх тохиолдол гардаг хугацааг ижил болгох тал дээр анхаарах нь зүйтэй байна.
- Үүрэн телефоны операторууд манай аймагт иргэд хөдөлмөрчдийн хэрэгцээг хангаж ажиллаж байгаа нь нэг талаар сайн үзүүлэлт боловч, зах зээлийн өрсөлдөөн ихтэй, төвдөө төвлөрсөн удирдлагатай тайлан баланс гардаггүй гэдгээр манай статистик мэдээлэлд хамрагдах боломжгүй байдаг Хойшид үүрэн телефонууд аймагтаа нэгдмэл удирдлаган дор мэдээлэлд хамрагдаж байх нь хуулийн заалтад нийцэх юм.
- Манай аймагт бүртгэлтэй ААНБ-ын удирдлага, санхүүгийн ажилтнууд нь УБ хот болон өөр аймгаас үйл ажиллагаагаа удирдаж явуулж байдаг тээврийн болон уул уурхайн компаниуд их байна. Энэ компаниудын мэдээллийг оршин байгаа орон нутгийн статистикийн нэгжээр мэдээллийг авахуулах тал дээр анхаарч ажиллах.

Энэхүү судалгааны хамрах хугацаа нь 2015, 2016, 2017, 2018, 2019 оны гүйцэтгэлээр харууллаа.

Ашигласан материал:

Жилийн эцсийн мэдээ, тайлан мэдээнүүд

ДНБ-ний тооцоо улс, аймаг, 2015-2019 оны статистикийн эмхтгэл

www.1212.mn сайтаас улс, бүсийн түвшинг харьцуулсан үзүүлэлт зэргийг ашиглав.